



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 1/408

Улаанбаатар хот

Аян зохион байгуулах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйл, 48 дугаар зүйлийн 48.3.4 дэх заалт, 51 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, 57.12 дахь заалтууд, Засгийн газрын "Журам батлах тухай" 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2015 оны "Журам батлах тухай" 189, 2019 оны "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм" батлах тухай 406 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл" аяны удирдамжийг нэгдүгээр, эрүүл мэндийн байгууллагыг үнэлж, шалгаруулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү аяныг 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл эхлэн зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. "Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл" аяныг үнэлэн урамшуулал, нэмэгдлийг Эрүүл мэндийн байгууллага батлагдсан төсөвтөө багтаан зарцуулахыг дарга, захирал нарт зөвшөөрсүгэй.

4. Аяны зохион байгуулалт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Я.Амаржаргалд даалгасугай.



141201490

2020 оны 08 сарын 11

Эрүүл мэндийн сайдын
тушаалын
нэгдүгээр хавсралт



“Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл” аяны удирдамж

Нэг. Үндэслэл

1.1 Эрүүл мэндийн салбарын нэр хүнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд нөлөөлөх чухал хүчин зүйл бол нотолгоонд суурилсан мэдлэг, мэргэшлийн ур чадвар, эерэг хандлага, ёс суртахуунтай хамт олны нэгдэл байдаг. Аяны хүрээнд хамт олны эерэг хандлага, харилцааны соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг ханган ажиллахад чиглэнэ.

Хоёр. Зорилго

2.1 Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтаны ёс зүй, хамт олны харилцаа хандлага, байгууллагын соёлыг сайжруулахад оршино.

Гурав. Хамрах хүрээ

3.1 Эрүүл мэндийн байгууллагын бүх тасаг, алба, нэгж хамаарна.

Дөрөв. Хугацаа

4.1 Аяны үргэлжлэх хугацаа нь 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл явагдана.

Тав. Аяны хүрээнд зохион байгуулагдах ажлын чиглэл

5.1. Эрүүл мэндийн ажилтан, байгууллагад чиглэсэн үйл ажиллагаа

5.1.1. Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн тасаг, нэгж бүр уриа, зорилгоо тодорхойлно.

5.1.2. Эрүүл мэндийн байгууллага ажилтны хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн хөгжлийн хөтөлбөрийг дотооддоо батлан хэрэгжүүлнэ.

5.1.3. Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн тасаг, нэгж 5.1.2-д заасан хөтөлбөрийн дагуу эерэг хандлагын ач холбогдлын талаар шинэ санаа, санаачлага гарган, бодит үр дүнд хүргэнэ.

5.1.4. Гурван сарын хугацаанд хандлага, тусламж, үйлчилгээний чанарын чиглэлээр 2-оос дээш бүтээлч, шинэ санааг тасагтаа хэрэгжүүлэн бодит үр дүнд хүргэнэ.

5.1.5. Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн тасаг, нэгжийн хамт олон эерэг өөрчлөлтийг эхлүүлэн бодит үр дүнд хүргэнэ.

5.1.6 Эрүүл мэндийн байгууллагын тасаг, нэгж бүр ажлын байрны 5С хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.1.7 Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн тасаг, нэгж эмч, сувилагч, үйлчлэгч, ажилтнууд энгэрийн тэмдгийг зүүж хэвших, хувцсаар жигдрэнэ.

5.1.8 Хамт олонтойгоо найрсгаар мэндэлж, эерэг хэвшилд суралцана.

5.1.9 Эмнэлгийн тасаг, нэгж бүр хамт олныхоо гаргасан амжилт бүрт баяр хүргэж, урамшуулдаг болсон байна.

5.1.10 Үйлчлүүлэгчдээс ирсэн талархалыг хамт олны дунд сурталчилна.

5.1.11 Эмнэлгийн мэргэжилтний баримтлах ёс зүйн дүрмийг сурталчлах, мөрдөлтөнд хяналт тавина.

5.2. Үйлчлүүлэгчдэд чиглэсэн үйл ажиллагаа

5.2.1 Эрүүл мэндийн ажилтнууд үйлчлүүлэгчидтэй инээмсэглэн мэндлэх, үдэх соёлыг хэвшүүлсэн байна.

5.2.2. Үйлчлүүлэгчидтэй хүндэтгэлтэй харилцан, эерэг харилцааг эрхэмлэн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

5.2.3 Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхдээ баримтлах эрх, үүргийг сурталчилна.

5.2.4. Үйлчлүүлэгчийн санал гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэх, судалгаа дүгнэлт гаргана.

5.2.5. Үйлчлүүлэгчийн эерэг хандлагад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Зургаа. Хүрэх үр дүн

6.1 Хандлагыг сайжруулах аяны хүрээнд эрүүл мэндийн ажилтанууд дараах чадварыг эзэмшинэ. Үүнд:

6.1.1 Ажилтнууд байгууллагын дотоод дүрэм, журамд нийцүүлэн, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг мөрдөж хэрэгжүүлнэ.

6.1.2 Өдөр бүхэн эерэг харилцаанд суралцан, асуудлыг эерэгээр шийдвэрлэх, инээмсэглэл, эерэг хандлагыг бусдад түгээнэ.

6.1.3 Эмч, ажилтан бүр хамт олноо эерэгээр үлгэрлэн харилцах чадвартай болно.

6.1.4 Тасаг хамт олон эерэг харилцааг хэвшил болгон нэгэн зорилгын төлөө ажиллах сэтгэлгээтэй болсон байна.

Долоо. Ажилтны хандлагыг үнэлэх, нэмэгдэл олгох

7.1 Эрүүл мэндийн ажилтны хандлага, харилцааг хүснэгтэн дэх шалгуур үзүүлэлтийн дагуу эмнэлэг, тасаг, нэгж өөрсдийн ажлын байрны нөхцөлтэй уялдуулан хяналт, үнэлгээний хуудас боловсруулан 7 хоног бүр үнэлнэ.

7.2 Байгууллагын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг ажилтнуудын хандлагад явцын хяналтыг сар бүр хийнэ.

7.3 Хяналт, үнэлгээ хийхдээ ажилтны өөрийн үнэлгээ, шууд харьяалан удирдах ажилтны үнэлгээ, хамт олны төлөөллийн үнэлгээ, үйлчлүүлэгчийн үнэлгээ зэргийг харгалзан дүгнэнэ.

7.4 Үнэлгээгээр 100% үнэлэгдсэн ажилтанд хандлагын нэмэгдлийг олгоно.

7.5 Хандлагын нэмэгдлийг ажилтны сарын үндсэн цалингаас 10%-иар тооцон олгоно.

7.6 Хандлагыг үнэлэх шалгуур үзүүлэлт /хүснэгтэнд/

№	Үзүүлэлт	Шаардлага		Шалгуур
1	Мэндчилэх, үдэх харилцаа	Үйлчлүүлэгчтэй мэндлэхдээ	<p>Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь үйлчлүүлэгчтэй эхэлж мэндлэх ба нүүр царайны төрхөө эерэг сэтгэгдэл төрүүлэхүйц байлгаж, үйлчлүүлэгчийн нүдрүү харан эелдгээр инээмсэглэн мэндчилэх</p> <p>Үйлчлүүлэгчийн нэрийг мэдэж буй тохиолдолд нэрийг хэлээд хүндэтгэн мэндлэх</p> <p>Анх уулзаж буй тохиолдолд мэндэлсний дараа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь өөрийгөө танилцуулах</p> <p>Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь мэндчилгээ, талархал, уучлал хүсэлтийг тухай бүрт тохируулан илэрхийлэх</p> <p>Үйлчлүүлэгчийг үзлэгийн өрөө, эмнэлгээс гарах үед суудлаасаа босон биеэ бодоорой, хурдан эдгээрэй зэрэг тааламжтай үгс хэлж үдэн гаргах</p>	<p>Үйлчлүүлэгчээс гомдол гараагүй, сэтгэл ханамж эерэг байх</p> <p>Сэтгэл ханамж 90%-иас дээш байх</p> <p>Гомдол саналын тоонд харьцуулан хувийг тооцох</p>
		Ажилтан хоорондоо мэндлэхдээ	<p>Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь өөр хоорондоо адил хүндэтгэлтэй мэндэлж харилцах</p> <p>Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь мэндчилгээ, талархал, уучлал хүсэлтийг тухай бүрт тохируулан илэрхийлэх</p>	Ажилтнаас гомдол, санал гараагүй, хамт олны дунд сэтгэл ханамж эерэг байх
2	Энгэрийн тэмдэг зүүлт	Бүх ажилтан	Энгэрийн тэмдгийг тогтмол зүүж хэвшсэн байх	Бүх ажилтан энгэрийн тэмдэг 100 хувь зүүж хэвшсэн байна.
3	Ажлын байранд	Эмнэлгийн мэргэжилтэн нь	Эмнэлгийн малгай - Үсийг бүрэн далдалсан	

	<p>мөрдөх хувцаслалт</p>	<p>дүрэмт хувцсыг зориулалтын дагуу зөв өмсөх /ЭМС-ын 189 тоот тушаалын дагуу/</p>	<ul style="list-style-type: none"> - Халдвараас сэргийлэх нөхцлийг хангасан байх Ажлын хувцасны ханцуй - Мөрийг заавал далдалсан урт ба богино ханцуйтай Ажлын богино халад - Энгэрийн ухлаадас нь зөвхөн эгэм хүрсэн, шулуун, энгийн загвартай Ажлын урт халад - Бие бариагүй, шулуун, ажил хэрэгч, өвдөг түүнээс доош 5 см - Ажлын онцлогоос хамаарч бүс, бүч уяа хэрэглэж болно. Ажлын өмд - Бие бариагүй, хөдөлгөөн хязгаарлахгүй - Урт нь шагай хүрсэн - Энгийн загвартай Гутал - Эмнэлгийн зориулалттай зөөлөн ултай, хальтардаггүй - Хөлийн хуруу ил гараагүй - Гутлын өсгий 5.5 см-ээс өндөргүй эсвэл үргэлж ултай Эмнэлгийн хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл - Зааврын дагуу өмсч, тайлж хэвшсэн байх 	<p>Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан дүрэмт хувцсыг зөв өмсч хэвшсэн байна.</p> <p>Хяналтын хуудасны үнэлгээгээр</p>
		<p>Эмнэлгийн удирдах болон бусад ажилтан</p>	<p>Эмнэлгээс олгосон тусгай дүрэмт хувцас болон халадыг зориулалтын дагуу өмсөх /Захиргаа болон дэмжих хэсгийн албадын ажилтаны хувцаслалт, үс засалт, хумс засалтыг тодорхой хэмжээнд зөвшөөрч болно /</p>	
<p>4</p>	<p>Ажлын байранд биеэ авч явах соёл</p>	<p>Эмнэлгийн мэргэжилтэн, удирдах болон бусад ажилтан</p>	<p>Ажлын хувцасны хэрэглээ</p> <ul style="list-style-type: none"> - Дүрэмт хувцасны цахилгаан ба товч бүрэн товчлогдсон, хир толбогүй Хувийн гар утас хэрэглэх - Тусламж, үйлчилгээ үзүүлэхээс бусад нөхцөлд гар утсыг ажлын байранд хэрэглэх бол нам дуугаар хариулах буюу гар утасны хонхыг зөвхөн чичиргээ тохиргоонд тааруулах Албаны утас - Утсыг авахдаа эхлээд мэндэлж, тухайн ажлын байрны нэр, өөрийн нэрийг хэлэх 	<p>Эрүүл мэндийн ажилтан биеэ зөв авч явах соёл хэвшсэн байна</p>

			<p>Биеийн шивээс</p> <ul style="list-style-type: none"> - Шивээстэй бол ажлын дүрэмт хувцсаар бүрэн далдлах - Нүүр гарын ил хэсэгт шивээс хийлгэхийг зөвшөөрөхгүй <p>Толгойн үс</p> <ul style="list-style-type: none"> - Цэвэр, самнасан - Үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлэхэд саад болохооргүй - Урт бол шууж боосон - Ажил хэрэгч самналттай - Үсийг тод өнгөөр будаагүй <p>Нүүрний үс</p> <ul style="list-style-type: none"> - Хамар ба чих доторх үсийг зохих түвшинд арчилсан - Сахлыг хэвийн хэмжээнд засуулсан дээд уруул даваагүй байх <p>Нүүр будалт</p> <ul style="list-style-type: none"> - Хэвийн хэмжээнд бие арчлах энгийн түвшинд байх <p>Харааны шил</p> <ul style="list-style-type: none"> - Энгийн хэлбэр, загвар, өнгөтэй байна <p>Гарын хумс</p> <ul style="list-style-type: none"> - Хиргүй, цэвэрхэн - Богино засалттай, будаггүй <p>Бусад</p> <ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн мэргэжилтэн энгийн жижиг ээмэг, зүүлт зүүх ба энгэрийн цаг хэрэглэж болно - Бөгж зүүхгүй - Хурц үнэртэн хэрэглэхгүй 	<p>Байгууллага бүр журам боловсруулсан байна. Түүний мөрдөлтөнд дотоодын хяналт үнэлгээ хийгдэж хэлэлцэгдсэн байна.</p>
5	Сонсох чадвар	Эмнэлгийн мэргэжилтэн, удирдах болон бусад ажилтан	<p>Харилцагчийн ярьж байгаа яриаг үнэн сэтгэлээсээ, анхааралтай, идэвхитэй, тэвчээртэй, бүрэн сонсох, сонсож буйгаа илэрхийлэн толгой дохих</p> <p>Сонсох явцад яриаг тасалдуулахгүй, асуух зүйлийг тэмдэглэн бүрэн сонссоны дараа асууж тодруулах зүйлийг асуух, чиглүүлсэн асуулт тавих</p>	Ажилтан болон үйлчлүүлэгчээс гомдол, санал гараагүй байна
6	Эелдэг харилцаа	Эмнэлгийн мэргэжилтэн, удирдах болон бусад ажилтан	<p>Харилцаа:</p> <ul style="list-style-type: none"> - Үйлчлүүлэгчид ойрхон, нүдний харц нэг түвшинд байх - Нээлттэй энгийн ойлгогдох асуулт тавьж, ярилцах, санаа бодлоо илэрхийлэх боломж олгох 	

			<ul style="list-style-type: none"> - Үйлчлүүлэгч бүрт хувьчлан хандаж сэтгэл зүйн хувийн онцлогт тохируулан харьцах - Үйлчлүүлэгчээ гүйцэд сонсож, асуудлын дотоод шинж чанарыг тогтоож харьцах - Үйлчлүүлэгчийн дотоод сэтгэл, сэтгэл хөдлөлийг анхаарч харилцах - Дууны өнгө хүндэтгэсэн аястай байх - Асуудлыг тайлбарлахдаа намдуу дуугаар зөвлөсөн, дэмжсэн өнгөөр харилцах - Үйлчлүүлэгчид гадуурхах хандлага гаргахгүй байх - Хүндэтгэх, хувийн нууцыг нь хадгалах - Харилцах явцдаа утас болон компьютероор бичлэг үзэх, дуу сонсох, утсаар ярих зэрэг үйлдэл гаргахгүй байх - Мэргэжлийн болон орчин үеийн үг хэллэг хэрэглэхээс татгалзах, товч, тодорхой энгийн үгээр харилцагчдаа тохируулж ярих, хайхрамжгүй хандахгүй байх - Үйлчлүүлэгчийн хэрэгцээг тодорхойлох, харилцаагаа эерэгээр төгсгөх, дүгнэлт хийх 	Ажилтан болон үйлчлүүлэгчээс гомдол гараагүй байна
			<p>Биеийн хэлэмж:</p> <ul style="list-style-type: none"> - Үйлчлүүлэгчтэй харилцах үедээ бие, нүүрний төрхийг эерэг байдлаар төвлөрүүлэн харилцах - Үйлчлүүлэгчтэй зөрж өнгөрөхдөө мэндлэх, анхаарч байгаага илэрхийлэх - Гарын дохио зангаа, нүдний хөдөлгөөн болон бусад үйл хөдлөлд анхаарах - Яаруу сандруу дүр төрх гаргахгүй байх 	
7	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийн мөрдөлт	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан	<p>Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн тулгуур зарчмыг баримтлах</p> <ul style="list-style-type: none"> - Хүнлэг энэрэнгүй байх - Хүндэтгэлтэй хандах - Чин үнэнч, шударга байх - Хүн бүрт тэгш хандаж, үл ялгаварлах - Хариуцлагатай байх, боловсорч хөгжих 	

			<p>Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүйн дүрэм /ЭМСайдын 2019 оны А/406 тоот тушаалын мөрдөлт/</p> <ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчтэй харилцах хэм хэмжээг мөрдөх - Эмнэлгийн мэргэжилтэн хоорондын ёс зүйн хэм хэмжээ - Эмнэлгийн мэргэжилтэн нийгэмтэй харилцах хэм хэмжээ - Эмнэлгийн мэргэжилтний зан үйлийн хэм хэмжээ - Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтны ёс зүйн хэм хэмжээ 	<p>Ажилтан болон үйлчлүүлэгчийн санал, гомдол буурсан байна.</p>
8	Хандлага	Эмнэлгийн нийт ажилтан	<ul style="list-style-type: none"> - Эрхэлж буй мэргэжлээрээ бахархдаг байх - Шинийг сурах бүтээх, урагшлах тэмүүлэлтэй байх - Өөрийн үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрдөг байх - Аливаа зүйлийн өөрчлөлт, шинэчлэлийг эерэгээр хүлээн авдаг байх - Үзэл бодол, санал хүсэлтээ эелдгээр зөв боловсон илэрхийлдэг байх - Өөрийн алдаа, бурууг ухамсарлан хүлээн зөвшөөрдөг, уучлал хүсч чаддаг байх - Зөв бодол санаа, зөв үйлдэлтэй байх - Ажил, хамт олондоо сэтгэл ханамжтай байх 	<p>Ажилтнуудад эерэг хандлага төлөвшсөн байна.</p> <p>Ёс зүй, харилцаа, хандлагын талаарх гомдол буурсан байна.</p>

Найм. Тасаг, нэгж, албадын хандлагын ажлыг үнэлэх

8.1 Байгууллагын хэмжээнд нийт ажилтнуудын хандлагыг ажилтны сэтгэл ханамжийн судалгаагаар үнэлнэ.

8.2 Аян хэрэгжихээс өмнө нийт ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгааг авах ба аян хэрэгжиж дууссаны дараа уг судалгааг давтан авч ажилтнуудын сэтгэл ханамжийг харьцуулан үнэлнэ.

8.3 Тасаг, нэгжийн хамт олны харилцаа хандлагыг сайжруулах аяны үр дүнг үнэлэх шалгуур

№	Хэрэгжүүлэх ажил	Шалгуур	Үнэлгээ
1	Удирдамжийн дагуу хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн хөгжлийн хөтөлбөрийг дотооддоо батлан хэрэгжүүлэх	Батлагдсан хөгжлийн хөтөлбөр Батлагдсан ажлын төлөвлөгөө	10
2	Аяны тайланг шаардлагын дагуу бичиж, заасан хугацаанд ирүүлэх	Байгууллагын тайлангийн загвараар бичигдсэн байх, бодит зураг, хийгдсэн ажлуудыг хавсаргасан байна	10
3	Тасаг, нэгж бүр уриа, зорилгоо тодорхойлсон байх	Уриа, зорилгоо харагдахуйц газарт байршуулсан байх ба ажилтан бүр мэддэг байна.	10
4	Ажлын хувцсаар бүрэн жигдрэх	Хувцаслалтаар бүрэн жигдэрсэн байна /Ажлын хэсэг ажлын байран дээр очиж үнэлэх/	10
5	Энгэрийн тэмдэг зүүж хэвших	Энгэрийн тэмдэг зүүж хэвшсэн байна /Ажлын хэсэг ажлын байран дээр очиж үнэлэх/	10
6	Мэндлэлт, харилцаа, биеэ авч явж буй соёл	Ажлын байран дээр ажлын хэсэг очиж үнэлэх	10
7	Харилцаа, хандлагатай холбоотой гомдол гараагүй байх	Чанар аюулгүй байдлын алба болон Ёс зүйн салбар хороо, тасаг, нэгжид гомдол, санал гараагүй байна	10
8	ЭМС-ын 2019 оны А/406 тоот "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм"-ийн сургалт зохион байгуулах	Ажилтнуудад ёс зүйн дүрмийн сургалт зохион байгуулсан байна. Тайланд зураг болон гарын үсгийн баталгаажилт	10
9	Шинэ санаа, санаачлага гаргасан байх	Шинэ санаа, санаачлага гарган ажил хэрэг болгосон, үр дүнг тайланд баримтжуулсан байна	10
10	Хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн хөгжлийн хөтөлбөрийг дотооддоо хэрэгжүүлснээр гарсан үр дүнг тооцсон байх	Байгууллага, тасаг нэгжийн хэмжээнд хэмжигдэхүйц, үнэлэгдэхүйц өөрчлөлт гарсан байна	10
Нийт			100 оноо

8.4 Журмын 8.3-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу тасаг, нэгж бүрийг үнэлэх ба онооны дарааллаар жагсаан байр эзлүүлнэ.

Ес. Шагнал урамшуулал

9.1 Нэгдүгээр байрт шалгарсан тасаг, нэгжийн ажилтнуудад нэг улирлын мөнгөн урамшууллыг сарын 20 хувиар тооцож олгоно.

9.2 Хоёрдугаар байрт шалгарсан тасаг, нэгжийн ажилтнуудад нэг улирлын мөнгөн урамшууллыг сарын 15 хувиар тооцож олгоно.

9.3 Гуравдугаар байрт шалгарсан тасаг, нэгжийн ажилтнуудад нэг улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сарын 10 хувиар олгоно.

9.4 Хамгийн сүүлийн 3 байранд орсон тасаг, нэгжийн ажилтнуудын үр дүнгийн мөнгөн урамшууллыг нэг улирлын турш хасаж хариуцлага оногдуулна.

9.5 “Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл” аянд 1, 2, 3-р байр эзэлж, шалгарсан тасаг, нэгжийн ажилтнуудын нэрсийг дарга, захирлын тушаалаар батлан, үр дүнгийн мөнгөн урамшууллыг 9.1, 9.2, 9.3-д заасан хэмжээгээр олгоно.

Арав. Байгууллагын тайлагналт, урамшуулал

10.1 “Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл” аяны үйл ажиллагааны явцад Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо, салбар хороо хяналт тавина.

10.2 Аяны хэрэгжилтийн тайланг аймаг, нийслэл дэх эрүүл мэндийн байгууллага 2020 оны 11 дүгээр сарын 30-ны дотор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт явуулна.

10.3 Төв эмнэлэг, тусгай мэргэшлийн төв, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нэгтгэж дүгнэсэн тайлангаа Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газарт 12 дугаар сарын 5-ны дотор ирүүлсэн байна.

10.4 Эрүүл мэндийн байгууллагуудын “Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл” аяны тайлан, үр дүнг үнэлж, шалгарсан 3 байгууллагыг урамшуулна.

2020 оны 08 сарын 17



“Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл” аяны
Эрүүл мэндийн байгууллагыг шалгаруулах ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч:

Эмнэлгийн тусламжийн газрын дарга

Ажлын хэсгийн нарийн
бичгийн дарга:

Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй
байдлын хэлтсийн Эмнэлгийн мэргэжилтний
ёс зүй хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын
хороо, салбар хорооны дэд дарга, гишүүд

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын
газрын мэргэжилтэн

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Магадлан,
итгэмжлэл лицензийн албаны дарга